



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/184

Мандалговь

Залуучуудын хөгжлийн салбар
зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 22 дугаар зүйлийн 22.1, 22.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, төрийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. Залуучуудын боловсрол, соёл, эрүүл мэнд, биеийн тамир, хөдөлмөр эрхлэлт, хувь хүнийг хөгжлүүлэх талаар олон талт үйл ажиллагааг жил бүр төлөвлөн, зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (Ц.Ганзориг)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Аймгийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/82 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210301